



ТҮҮХ, НИЙГМИЙН УХААНЫ БАГШ Н.АНУДАРИЙН  
ТАЙЛАН

2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ

2019 он

## Агуулга

1. Төлөвшил .....	3
1.1. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал .....	3
1.2. Бусадтай харилцах зан чанар .....	4
1.3. Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал, хэвшил, зан чанарын байдал.....	4
1.4. Жижүүр багшийн үнэлгээ.....	5
1.5. Судалгаа хийсэн байдал .....	5
2. Хүүхэд нэг бүрийн эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц амжилт.....	7
2.1. Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /moodle/.....	7
3. Авьяасыг нээн хөгжүүлсэн байдал.....	9
3.1. Дугуйлан секцэд хамрагдсан сурагчдын судалгаа .....	9
3.2. Уншсан номын тэмдэглэл хөтөлсөн эсэх.....	9
3.3. Олимпиад уралдаан тэмцээн .....	10
3.4. Бүтээлч ажил.....	10
3.5. Хүүхэд нэг бүрийн оролцоог хангаж анги нийтээрээ хөгжсөн байдал.....	10
4. Боловсролын сэтгэл ханамж .....	11
4.1. Цаг ашиглалт.....	11
4.2. Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн .....	11
4.3. Багшийн хичээлийн бэлтгэл, сургалтын техник хэрэгсэл ашигласан байдал.....	11
5. Эрүүл мэнд.....	12
5.1. Эрүүл мэндийн анхан шатны дадал хэвшилд сургаж үлгэрлэсэн байдал.....	12
Хавсралт.....	13

## 1. Төлөвшил

### 1.1. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал

2018-2019 оны хичээлийн жилийн II хагас жилийн хугацаанд түүх, нийгмийн ухааны багш Н.Анударь миний бие дараах үйл ажиллагаанд оролцсон байна. Үүнд:

- ✓ “Цэнэглэх цаг”-ийн хүрээнд “Луужингийн стратеги” сэдэвт лекцэнд хамрагдсан./2018.10.17/
- ✓ “Цэнэглэх цаг”-ийн хүрээнд “Эрүүл мэнд гоо сайхан” сэдэвт сургалтанд хамрагдсан./2018.12.03/
- ✓ Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд “Эко” сургалтанд хамрагдсан.
- ✓ Бага ангийн сурагчдын дунд “Миний эргэн тойрон- миний эрх” гар зургийн уралдааныг сургуулийн захиргаа болон ЗАН хамтран зохион байгуулсан./2018.12.7/
- ✓ Дунд ангийн сурагчдын дунд “Цахим орчин ба хүүхдийн эрх” бүтээлийн уралдааныг сургуулийн захиргаа болон ЗАН хамтран зохион байгуулсан./2018.12.7/
- ✓ Ахлах ангийн сурагчдын дунд “Үе тэнгийн дээрэлхэлт” сэдвээр хэлэлцүүлгийг сургуулийн захиргаа болон ЗАН хамтран зохион байгуулсан./2018.12.6/
- ✓ JICA-аас зохион байгуулсан “мэдээлэл харилцааны технологийн арга зүй” сэдэвт 3 өдрийн сургалтад хамрагдсан./2018.12.6-12.9/
- ✓ Дунд болон ахлах ангийн сурагчдын дунд “Хувь хүний хөгжил-хөгжих эрх” сэдэвт лекцийг Манлайллын Боловсролын Үндэсний төвийг тэргүүн Б.Батням лекторыг урин сургуулийн захиргаа болон ЗАН хамтран зохион байгуулсан./Хавсралт зураг 5./
- ✓ Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг “Үе тэнгийн дээрэлхэлт” төсөлт хөтөлбөрийн модуль II хамрагдсан./2018.12.17/ /Хавсралт зураг 6./
- ✓ Moodle уралдааны хүрээнд moodle сургалтанд хамрагдсан./2018.1.7-1.11/ /Хавсралт зураг 4./
- ✓ “Эерэг бол гоё” уриан дор залуу багш нарын дунд зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцож дэд байр эзэлсэн./Хавсралт зураг 3/
- ✓ “Авьяаслаг 23” урлагийн наадамд зохион байгуулалтаар ажиллаж, туршлага хуримтлуулсан./2018.11.17-11.18/
- ✓ Сургуулийн шинэ жилийн арга хэмээний “Яг түүн шиг” хөгжөөнт тэмцээнд дуучин Ука болж амжилттай оролцсон.
- ✓ Цахим номын сангийн нээлт болон танилцуулах үйл ажиллагааны зохион байгуулалтад оролцсон.
- ✓ Чингэлтэй дүүргийн залуу багш нарын спортын өдөрлөгт оролцож, шилжин явах цом авсан.

- ✓ Нийслэлийн “Тамирчин багш- 2019”-д түүх, нийгэм судлалын судлагдахууны багш нартай баг болж хамтран оролцсон.
- ✓ Эцэг эхийн нээлттэй хаалганы өдөрлөг үйл ажиллагааны зохион байгуулалтаар ажилласан.
- ✓ Гадаад хэлний баярын үйл ажиллагаанд шагнал гардуулах үйл ажиллагааны зохион байгуулалт хийсэн.
- ✓ “Moodle” системийн танилцуулга үйл ажиллагаанд оролцож мэргэжлийн судлагдахууны тестийн сан бүрдүүлсэн.

## **1.2. Бусадтай харилцах зан чанар**

Сургуулийн орчинд өөрийн харилцах чадвар, зан чанарт дараах хэвшлүүдийн суулгасан.

Үүнд:

- ✓ Багш болон ажилчидтайгаа инээмсэглэж харилцах,
- ✓ Багш болон ажилчидтайгаа тогтмол мэндэлж байх,
- ✓ Сурагчидтай нээлттэй харилцах,
- ✓ Цаг баримтлах,
- ✓ Төлөвлөгөөтэй байх,
- ✓ Сайн сонсогч байх ,
- ✓ Цаг тухайд нь ажлаа хийж байх,
- ✓ Сэтгэлтэй байх

## **1.3. Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал, хэвшил, зан чанарын байдал**

Ээлжит хичээлийг бэлтгэхдээ ихэвчлэн цахим хичээл бэлтгэдэг бөгөөд сурагчдад бие даан хийх ажлаар судалгаа, бичлэг, баримтат кинонд дүн шинжилгээ хийлгэх зэрэг үйлүүдийг түлхүү хийлгэж байна. Энэ нь сурагчдад дараах эерэг үр дүнг авчирсан.

- ✓ Эсээ бичүүлж, зөвлөгөө өгөх- сурагч бүрээр 1 эсээ бичүүлж, бичсэнбайдалд тулгурлан зөвлөгөө өгч эргэж шалгаж зөвлөгөө өгч ажилласан. Энэ нь сурагчид эсээ бичих арга барилд суралцаж, өөрийн санааа бодлыг сул үг ашиглалгүйгээр шинжлэх ухааны хэлээр ярих бичих хэвшилд суралцах эерэг нөлөө гарсан.
- ✓ Судалгаанд дүн шинилгээ хийлгэх- нийгмэмд тулгамж буй асуудлуудаас судалсан, шийдвэрлэх арга замыг боловсруулсан судалгааны ажлыг сурагчид уншиж судалсанаар судалгааны арга зүй хийгээд юмс үзэгдлийг судлах арга барилд суралцсан.

- ✓ Хичээлийн болон хичээлийн бус цагаар сурагчдын харилцаанд нэг нэгнийгээ сонсох, хүндэлтэй байх, өөрийгөө чөлөөт цагаар яаж хөгжүүлэх, хувийн менежментийг хэрхэн хийх талаар зөвлөгөө өгсөн.

#### **1.4. Жижүүр багшийн үнэлгээ**

II хагас жилийн хугацаанд 2 удаа жижүүр багшийн үүрэг гүйцэтгэсэн. /Хавсралт 1./

- ✓ 2019.3.29-ны өдөр жижүүр багш хийж 30 оноо авсан.
- ✓ 2019.5.21-ны өдөр жижүүр багш хийж 30 оноо авсан.

#### **1.5. Судалгаа хийсэн байдал**

II хагас жилийн хугацаанд өөрийн багшлах үйл ажиллагаатай холбоотой сурагчдаас нээлтэй асуулга авж өөрийн мэргэжлийн үйл ажиллагаанд тусгасан. Үр дүнд:/Хавсралт 2./

- ✓ Цахим хичээлийг түлхүү бэлтгэх
- ✓ Хичээлийн цагаар хичээлээ заахдаа чанга дугарах
- ✓ Сурагч нэг бүрийг саналыг сонсох
- ✓ Баримтат кино, бичлэг тогтмол үзүүлж, дүн шинжилгээ хийлгэж байх

Түүнчлэн хичээлийн бус цагаар өөрийн судалгаа шинжилгээний ажлыг сайжруулж, судалгааны арга зүйд суралдцаж дараах судалгааг хийсэн.

#### **1. Цахим хэрэглээний өнөөгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ**

Судалгаа нь өсвөр насны хүүхдүүд болон залуучуудын цахим хэрэглээний өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, шийдвэрлэх саналыг дэвшүүлэх зорилготой байсан. Зорилгын хүрээнд хийгдсэн судалгааны дүнд дараах үр дүн гарлаа. Үүнд:

- ✓ Цахим хэрэглээний талаарх ойлголт хүүхэд болон насанд хүрэгчдийн хооронд харилцан адилгүй ялгаатай байна. Энэ нь нийгэмд эзлэх байр сууриас шалгаалах талтай болох нь харагдлаа.
- ✓ Өсвөр насны хүүхдүүд цахим хэрэглээний зохистой хэрэглээг мэдэх боловчиг зохистой хэрэглэж чаддаггүй болох нь илэрлээ.
- ✓ Цахим хэрэглээний зохистой хэрэглээг төлөвшүүлэх шаардлага тулгарч байна.

#### **2. Гэр бүл, түүнд тулгамдаж буй асуудал**

- ✓ Залуу гэр бүл дэх тулгамдаж буй асуудалд нийгэм эдийн засгийн хүчин зүйлс, хосуудын хувийн хүчин зүйл, бусад хүмүүсийн хүчин зүйл, нийгмийн байр суурь

зэрэг хүчин зүйлс нөлөөлөх бөгөөд энэ нь тухайн гэр бүлийн харилцаа, амьдралын хэв маяг, тогтолцоонд шууд нөлөө үзүүлж байдаг.

- ✓ Судлан шинжилсэн судалгааны бүтээлүүд болон хийгдсэн судалгааны ажлын үр дүнд залуу гэр бүлийн дунд эдийн засгийн эмзэг байдал, гэр бүлийн зөрчил маргаан, гэрлэлт цуцлалт, хүүхдийн хүмүүжил, залуу хосуудын гэрлэлтийн байдлаас үүдэлтэй стресс зэрэг нь тулгамдаж буй нийтлэг асуудал болохыг илрүүлсэн болно.
- ✓ Залуу гэр бүл дэх эдийн засгийн эмзэг байдлыг гол үндэс нь эдийн засгийн идэвхи өндөр боловч ажилгүйдлийн түвшин өндөр байна. энэ нь залуу гэр бүлийн орлогын хэмжээ доогуур түвшинд байх бөгөөд бие даан амьдрах, хэрэгцээгээ хангах, үр хүүхдээ өсгөн хмүүжүүлэх зэрэгт асуудал тулгарч байгаа юм. Тиймээс залуу гэр бүлийн эхнэр аль эсвэл нөхөр нь гадаад улсыг зорих, урт хугацаагаар тусдаа амьдран уул уурхайн ажил хийх зэрэг арга замыг сонгодог байна.
- ✓ Нийгэм эдийн засгийн хүчин зүйлс нь залуу гэр бүлийн зөрчил маргаанд ихээхэн нөлөөлдөг болох нь харагдсан бөгөөд түүний дараагаар гэр бүлийн гишүүдийн дотоод харилцаа, хосуудын хувийн зүйлс нөлөөдөг байна. Цаашлаад, тухайн зөрчил нь гэр бүлийн хүчирхийллийн үндэс болох ба залуу эмэгтэйчүүдийн 53,1% нь амьдралынхаа тушид хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан байна.
- ✓ Залуу гэр бүлийн хувьд стрессийн түвшин харьцангуй бага боловч гэрлэлтийн байдалтай холбоотойгоор стрессийн түвшин өндөр байна. энэ нь гэр бүл дэх үүрэг хариуцлага, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг хангах, өрхийн амьжиргааг дээшлүүлэх зэрэг үйлд ганаараа буюу бие даах нь стресст орох шалтгаан болдог байна.
- ✓ Гэр бүлийн гэрлэлт цуцлалт нь жилээс жилд өссөн хандлагатай бөгөөд үүнд нийгмийн шинэчлэл өөрчлөлт ихээхэн нөлөөлдөг байна. Түүнчлэн залуу гэр бүлд тулгамдаж буй асуудлууд нь гэрлэлт цуцлалтын шалтгааны нэг юм.
- ✓ Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал нь материаллаг нөхцөл, тэдний хэрэгцээтэй холбоотой асуудал бөгөөд үүнд төрөөс тусламж дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгаа нь харагдлаа. Тухайлбал орон байртай болох, амьдралын боломж нөхцөлөө дээшлүүлэх зэрэг зорилгоор залуу гэр бүлийн нөхөр эсвэл эхнэр нь гадаад улсыг зорих арга замыг сонгодог. Энэ нь улс дамнасан гэр бүлийг ихэсгэх, түүнчлэн гэр бүл салалтад нөлөө үзүүлж байна.

### 3. Үе тэнгийн дарамт дээрэлхэлтийн талаарх сурагчдын судалгаа/Хавсралт 3./

## 2. Хүүхэд нэг бүрийн эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц амжилт

### 2.1. Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /moodle/

2018-2019 оны хичээлийн жилийн III улирлын 9, 10, 11 дүгээр бүлгүүдэд түүх, нийгмийн ухааны хичээлийн ордог тул тэдгээрийн нэгж хөтөлбөрийн боловсруулалтыг хийсэн болно. /хавсралт 4./

- ✓ 9 дүгээр анги нийгмийн ухаан “Хувь хүн ба эрх зүй”, “Нийтийн удирдлага”
- ✓ 10 дугаар анги нийгмийн ухаан “Улс төр ба Олон улсын харилцаа”
- ✓ 11 дүгээр анги нийгмийн ухаан “Улс төр” болон “Олон улсын харилцаа”

Дээрх нэгж хичээлийн хөтөлбөр болон ээлжит хичээлийн нэмэлт мэдээлэл дасгал даалгаврыг дараах линкээр орж харах боломжтой. <http://59.153.84.101/moodle/my/>

### 2.2. Стандарт хэрэгжилт

2018-2019 оны хичээлийн жилийн II дүгээр улирлын үнэлгээ

Д\д	Анги	С\тоо	I	II	III	IV	V	VI	VII	VIII
Нийгэм										
1	9в	43	0	0	0	0	0	1	7	35
2	10в	41	0	0	0	0	0	0	15	26
3	10д	35	0	0	0	0	0	3	13	15
4	11в	53	0	0	0	0	0	0	13	39
5	11г	45	0	0	0	0	0	2	12	32
Түүх										
6	9в	43	0	0	0	0	0	3	14	26
7	10в	41	0	0	0	0	0	1	12	28
8	10д	35	0	0	0	0	0	5	17	14
9	11в	53	0	0	0	0	0	0	17	35
10	11г	45	0	0	0	0	0	2	6	36
	Нийт	434	0	0	0	11	48	40	124	212




График 1. II дүгээр хагас жилийн нийгмийн ухааны хичээлийн үнэлгээний түвшин

График 1.-ээс харахад анги бүлгийн дийлэнх буюу 38,1% нь VIII түвшин, 24,5% нь VII түвшин тус тус байна. Харин VI түвшин- 18,2%, V түвшин- 17,7%, IV түвшин- 1%, III түвшин- 0,2% буюу нийт 37,1% нь нийгмийн ухааны хичээлээр бие даан дасгал даалгавар хийх, тохиолдол шинжлэх замаар нийгмийн үзэгдэл үйл явдлын талаарх мэдлэг ойлголтыг судлах зэрэгт багш түлхүү анхаарах шаардлагатай болох нь харагдаж байна.

### 2.3. Хүүхэд бүрийн ахиц амжилтанд нөлөөлсөн байдал, бүтээлч ажил

II хагас жилийн хугацаанд хүүхэд бүрийг хичээлийн болон хичээлийн бус цагаар ахиц амжилт гаргахын тулд дараах бие даах ажлуудыг хийлгүүлсэн болно. Үүнд:

- ✓ 9 дүгээр анги- Түүхийн хичээлд он цагийн дарааллаар түүхэн үйл явдлыг зураглах, схем хийлгэсэн. Энэ нь түүхэн үйл явдлыг он цагийн дарааллаар танин мэдэх, түүхэн үйл явдалд дүн шинжилгээ хийх зэрэг арга барилд суралцуулсан.
- ✓ 10 дугаар анги- Тохиолдол шинжлэх замаар нийгмийн үзэгдэл үйл явдалд дүн шинжилгээ хийх, баримтат кино, бичлэг үзэх, судалгаа зэрэгт дүн шинжилгээ хийх замаар судалгааны арга, арга зүйд суралцаах зэрэг ахиц гарсан.
- ✓ 11 дүгээр анги- Нийгмийн ухааны хичээлээ эрх зүйн нэгжийн хүрээнд бие даах жилд хийлгэсэн. Энэ нь тест болон тохиолдол зэргээс бүрдэх ба сурагчид бие даан хийснээр иргэний болон захиргааны эрх зүйн харилцааг нарийвчлан судалж, нийгмийн харилцаанд оролцохдоо эрх зүйн харилцаанд тулгуурлах зэрэг ахиц гарсан.

### 2.4. Сурагчдын сурах үйлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байгаа байдал

Сурагчдын сурах үйл ажиллагаанд тулгамдаж буй түгээмэл асуудал нь гэрийн даалгавар дахь дасгал, даалгавар, ээлжит хичээлийн цагаар хийж гүйцэтгэх шаардлагатай дасгал ажил, бие даалтуудтай холбоотой байна. Үүнд багшийн зүгээс дараах арга хэмжээг авсан.

- ✓ Ээлжит хичээл бүрийн төгсгөлд сурагчдын дэвтэрт даалгаврыг хэрхэн, яаж хийх тэмдэглэл бичүүлэх, тайлбарлах
- ✓ Бие даалт, дасгал, даалгаврыг яаж хийх заавар зөвлөгөөг хичээлийн болон хичээлийн бус цагаар зөвлөн тусалсан.
- ✓ Сурах үйл ажиллагаанд тулгамдаж буй дарамт, стрессийг хэрхэн зохион байгуулах талаар өөрийн туршлагад тулгуурлан сурагчдад зөвлөн тусладаг.

### **3. Авьяасыг нээн хөгжүүлсэн байдал**

#### **3.1. Дугуйлан секцэд хамрагдсан сурагчдын судалгаа**

Сургуулийн илтгэх урлаг, мэтгэлцээний “Логос” клубийг III улирлаас удирдан авч, түүх, нийгмийн ухааны багш Б.Баярбат багштай хамтран сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан. Клубын үйл ажиллагааг хүлээн авсанаас хойш сургуулийн хэмжээнд Карл Попперийн мэтгэлцээний аварга шалгаруулах анхлан мэтгэлцээнийг зохион байгуулсан. Үр дүнд нийт 5 баг шалгарч Чингэлтэй дүүргийн аварга шалгаруулах Карл Попперийн мэтгэлцээнд оролцох эрх авсан. Түүнээс 1 багш тэргүүн байр эзэлсэн амжилт гаргалаа./Хавсралт 5./

Клубт харьяалалтай нийт дунд болох ахлах ангийн сурагчдын хүрээнд 35 суралцагч байна. Багш болон суралцагчдаас клубын үйл ажиллагааг сайжруулах үүднээс дараах санал зөвлөмжийг гаргасан. Үүнд:

- ✓ Клубын суралцагчдыг 2 түвшинд ангилж харилцан адилгүйгээр сургалтын хөтөлбөр боловсруулж, чадваржуулах
- ✓ Хичээлийг орохдоо илтгэх урлаг болох мэтгэлцээнээс гадна номын хэлэлцүүлэг өрнүүлэх
- ✓ Бие дан судалгаа хийлгэж, үр дүнг хамтран хэлэлцэх зэрэг өөрчлөлтдүүдийг хийх шаардлагатай.

#### **3.2. Уншсан номын тэмдэглэл хөтөлсөн эсэх**

Түүхийн хичээлийн хугацаанд Монголын нууц товчоог уншуулж, 10-р ангийн сурагчдаар оюуны зураглал хийлгэсэн. Үүнд: 10д болон 10в ангийн сурагчид хамрагдсан болно.(хавсралтаас оюуны зураглал хийсэн тэмдэглэлийг харна уу)/Хавсралт 6./

### **3.3. Олимпиад уралдаан тэмцээн**

- ✓ Чингэлтэй дүүргийн илтгэлээн уралдаанд 10а ангийн сурагч Т.Бодорьяа амжилттай оролцож, тусгай байр эзэлсэн.
- ✓ Чингэлтэй дүүргийн Карл Попперийн мэтгэлцээний аварга шалгаруулах тэмцээнд 11 ангийн Н.Азжаргал, М.Энхжин, Х.Цэнгүүн нар амжилттай оролцож гутгаар байр эзэлсэн.
- ✓ Чингэлтэй дүүргийн уран илтгэлийн тэмцээнд 9-р ангийн 10, 10 ангийн 1, 11 ангийн 1 сурагч амжилттай оролцож, нийт 4 сурагч нийслэлийн илтгэлийн уралдаанд оролцох эрхээ авсан. Түүнээс 9 ангийн сурагч Б.Оюуномин шалгарч улсын уран илтгэлийн тэмцээнд оролцож шилдэг илтгэгчийн батламж авсан.
- ✓ Чингэлтэй дүүргийн нийгэм судлал судлагдахууны олимпиадад 10-р ангийн 1 сурагч бэлтгэн оролцуулж тусгай байр эзэлж, нийслэлийн олимпиадад оролцох эрхээ авсан.

### **3.4. Бүтээлч ажил**

- ✓ Үе тэнгийн дарамт дээрэлхэлт, урьдчилан сэргийлэх талаар сургуулийн үе тэнгийн дээрэлхэлтийг баг хамтран хэлэлцүүлэгт хичээл зохион байгуулсан. Энэ нь үе тэнгийн дарамт дээрэлхэлт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сурагчдын үзэл бодлыг сонсхыг гол зорьсон.
- ✓ Хүүхдийг зодож шийтгэхгүй байх өдрийг тохиолдуулан Чингэлтэй дүүргээс зохион байгуулсан хэлэлцүүлэгт сурагчдыг бэлтгэж, хүүхдэд ээлтэй өрх гэр бүл, аюулгүй орчин, боловсрол зэрэг сэдвийн хүрээнд нийт сурагчдаас санал, хүсэлт авч нэгтгэн боловсруулсан. Чингэлтэй дүүрэг болон Нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан хэлэлцүүлэгт тавигдах илтгэлийг бичхэд сурагчдад зөвлөн тусалсан.
- ✓ Үе тэнгийн дарамт дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө илэрхийлэх ур чадвар сэдэв видео хичээлийг үе тэнгийн дээрэлхэлтийн баг, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хийсэн.
- ✓ Ахлах ангийн 100 сурагчдаас сурагчдын үе тэнгийн дээрэлхэлтийн талаарх судалгааг авч нэгтгэн боловсруулсан.

### **3.5. Хүүхэд нэг бүрийн оролцоог хангаж анги нийтээрээ хөгжсөн байдал**

- ✓ Үе тэнгийн дээрэлхэлт, түүнээс урьдчилан сэргээлийн өөрийгөө илэрхийлэх ур чадвар сэдэвт ахлах ангийн 10а ангийн сурагчдын хамруулж видео хичээл хийсэн.
- ✓ Үе тэнгийн дарамт дээрэлхэлт хэлэлцүүлэгт ахлах ангийн сурагчдын хамруулсан.
- ✓ Хүүхдийг зодож шийтгэхгүй байх өдрийг тохиолдуулж хүүхдийн дуу хоолойг сонсох хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үүнд дунд болон ахлах ангийн сурагчид хамрагдсан.

#### **4. Боловсролын сэтгэл ханамж**

##### **4.1. Цаг ашиглалт**

Хичээлийн болон хичээлийн бус цагаар ээлжит хичээлийн төлөвлөлт, бэлтгэлийг хангаж, сурагчдад зөвлөн туслах, багшлах арга зүйг сайжруулах үүднээс туршлагатай багш нараас зөвлөгөө авч, өөрийн ажилдаа тусган ажилладаг.

II хагас жилийн хугацаанд өөрийн ээлжит хичээлд туршлагатай багш нарыг нийт 5 удаа ажиглалт хийлгэж, багшлах арга зүйн зөвлөгөө авсан. Үр дүнд дараах арга барилд суралцлаа.

- ✓ Ээлжит хичээлийг заахдаа багш төвтэй бус сурагчт төвтэй байх
- ✓ Самбар төлөвлөлт дээр анхаарах
- ✓ Багшлах арга зүйгээ сайжруулж, туршлагатай багш нарын хичээлд сууж, суралцах
- ✓ Ээлжит хичээлийн цаг ашиглалтийг нарийн зохион байгуулалттай төлөвлөх шаардлагатай.

##### **4.2. Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн**

II хагас жилийн хугацаанд сурагчдаас сэтгэл ханамжийн судалгааг санамсаргүй түүврээр нээлттэй асуулгын аргаар судалгааг авсан. Дараах үр дүн гарсан.

- ✓ Багшлах арга зүйн хувьд: Цахим хичээл түлхүү ашиглаж, бага зэрэг тод дуугаар ярих зэргийг анхаарах шаардлагатай болох нь харагдсан.

*Ахлах ангийн сурагчийн ярианаас:*

Яг энэ хэвээрээ цахим хичээл орж байвал сонирхолтой байна.

- ✓ Сурагчидтайгаа тулгамдаж буй асуудлын талаар байнгийн зөвлөн тусалж, хэрхэн суралцах талаар нээлттэй ярилцаж байх

Сурагчдаас авсан нээлттэй судалгааны үр дүнд дээрх ойлголтуудыг цаашдын багшлах үйл ажиллагаанд тусгах шаардлагатай болох нь харагдлаа.

##### **4.3. Багшийн хичээлийн бэлтгэл, сургалтын техник хэрэгсэл ашигласан байдал**

Ээлжит хичээл бүрийн агуулгийг “moodle” цахим системд байршуулсан бөгөөд II хагас жилийн хугацаанд нийт нийгэм судлал судлагдахууны 24, түүхийн 14 цахим хичээл бэлтгэж орсон болно. Ээлжит хичээлийн бэлтгэл хангахад дараах хэрэглэгдэхүүн хэрэглэдэг.

- ✓ Хичээлийн үндсэн сурах бичиг
- ✓ Эх сурвалж мэдээлэл
- ✓ Цахим эх сурвалж ([www.1212.mn](http://www.1212.mn))
- ✓ Баримтат кино болон бага хэмжээний бичлэг, видео
- ✓ Power point

## 5. Эрүүл мэнд

### 5.1. Эрүүл мэндийн анхан шатны дадал хэвшилд сургаж үлгэрлэсэн байдал

- ✓ Ээлжит хичээлийн цагаар сурагчдад зөв суух дадал хэвшлийг сургаж, сурагчдын сурах сэдэл болон биеийн чилээг гаргах үүднээс хичээлийн цагаар гарын дасгал хийдэг.
- ✓ Ээлжит хичээлийн цагаар эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэхийн тулд сурагчдад зөвлөн тусладаг. Тухайлбал хоггүй байх, сандал ширээ цэгцтэй байх, цонх онгойлгож цэвэр агаар оруулах гэх мэт

### Дүгнэлт

2018-2019 оны хичээлийн жилийн хугацаанд хүүхэд нэг бүрийг хөгжүүлж, багшлан арга зүйг сайжруулахыг нэн түрүүнд зорисон болно. Дараах үр дүн гарлаа. Үүнд:

- ✓ Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд багшийн хичээл зүтгэл хамгийн их хэрэгтэй бөгөөд хичээлийн жилийн хугацаанд 9,10,11 дүгээр ангиудад орохдаа сурагчдыг дэмжин, санаа бодлыг сонсож, нээлттэй ярилцаж ажилласан. Цаашид хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд багшлах арга зүйд суралцах шаардлагатай.
- ✓ Хичээлийн болон хичээлийн бус цагаар багш өөрийгөө хөгжүүлэхэд анхаарах,
- ✓ Ээлжит хичээлийн бэлтгэлийг сайтар хангахын тулд туршлагатай багш нараас зөвлөгөө авах, мэргэжлийн багш нарын хичээлд сууж суралцах,
- ✓ Сургуулийн олон нийтийн үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцохын зэрэгцээгээр үндсэн ажлын чиг үүргээ гүйцэтгэн зохион байгуулалттай ажиллах
- ✓ Сурагч нэг бүрийг судлах

## Хавсралт



Зураг 1. Гадаад хэлний баярын үйл ажиллагаа



Зураг 2. Залуу багш нарын спорт өдөрлөг



*Зураг 3. Хичээлээс гадуурх илтгэх урлаг мэтгэлцээний Логос клуб тайлан хамгаалалт*



*Зураг 4. Хүүхдийг зодож шийтгэхгүй байх өдрийн тохиолдуулан зохион байгуулж буй хэлэлцүүлэг*



Зураг 5. Хүүхдийг зодож шийтгэхгүй байх өдрийг тохиолдуулан зохион байгуулсан хэлэлцүүлэг



Зураг 6. Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийн сургагч багш нар



*Зураг 6. Нийслэлийн аварга шалгаруулах мэтгэлцээний тэмцээний явц*



*Зураг 8. Чинэлтэй дүүргийн хэлэлцүүлэгт бэлтгэн танилцуулга хийж буй байдал*




Зураг 9. дүүргийн түүх, нийгмийн ухааны олимпиадад амжилттай оролцсон сурагчид захирлын хамт



Зураг 10. Цахим сургалтын танилцуулга үлй ажиллагааны угталтын баг



*Зураг 11. Чингэлтэй дүүргийн иргэдийн баяр*



*Зураг 12. Түүх, нийгмийн ухааны багш нар хамтран “Moodle” цахим системийг суралцаж буй байдал*